

## 4-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН БЛЮПРИНТ

Анги: 4

Хугацаа: 40 мин

### Даалгаврын зорилт

АТБХ	Суралцахуйн зорилт	Битүү /сонгох хариутай/ даалгавар				Нээлттэй /задгай/ даалгавар				Нийт
		Ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх	Бүгд	Ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх	Бүгд	
УНШ ИХ	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	2/2	2/2		4/4		1/2		1/2	5/6
Бичих	4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих	1/1			1/1					1/1
	4.2д Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой богино өгүүллэг зохиох	1/1			1/1					1/1
	4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, өгүүлбэрт зөв хэрэглэх			1/1	1/1					1/1
	4.2в. Ж, Ч,Ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих						1/3		1/3	1/3
	4.2ж Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих							1/5	1/5	1/5
ХЭЛ ЗҮЙ, ҮГСИЙН САН	4.4а Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд, зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	1/1			1/1		1/2		1/2	2/3
	4.4в Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох			1/1	1/1					1/1
	4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх			1/1	1/1		1/2		1/2	2/3
нэгтгэл	Даалгаврын оноо /даалгаврын тоо	5/5	5/5		10/10		4/9	1/5	5/14	15/24
	Онооны нийт эзлэх хувь	20.8%	20.8%		41.6%		37.6%	20.8%	58.4%	100%

### ОНООНЫ ХЭВИЙН ТАРХАЛТ

Танин мэдэхүйн түвшин	Сонгох даалгаврын оноо	Онооны эзлэх хувь	Задгай даалгаврын оноо	Онооны эзлэх хувь	Нийт оноо	Нийт онооны эзлэх хувь
Ойлгох	5	20.8%			5	20.8%
Хэрэглэх	5	20.8%	9	37.6%	14	58.4%
Задлан шинжлэх			5	20.8%	5	20.8%
НИЙТ оноо	10	41.6%	14	58.4%	24	100%

**ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ СХЕМ**

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний зорилт	хувилбар		Оноо	Онооны тайлбар
			“А” вариант	“Б” вариант		
<b>НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР</b>						
1	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Ойлгох	“Б”	“В”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
2	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Ойлгох	“Г”	“А”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
3	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Хэрэглэх	“В”	“Г”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
4	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Хэрэглэх	“Г”	“В”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
5	4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих	Ойлгох	“Б”	“Г”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
6	4.2д Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой богино өгүүллэг зохиох	Хэрэглэх	“В”	“В”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
7	4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, өгүүлбэрт зөв хэрэглэх	Хэрэглэх	“Г”	“А”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
8	4.4а Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд, зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	Ойлгох	“А”	“Г”	1	Зөв харгалзуулсан бол 1 оноо
9	4.4в Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	Хэрэглэх	“А”	“В”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
10	4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх	Хэрэглэх	“Г”	“А”	1	Зөв дугуйлсан бол 1 оноо
<b>ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР</b>						
11	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Хэрэглэх	Амьтадтай тоглосны дараа гараа тогтмол угаах, гарын ариун цэвэр сахих нь чухал гэдгийг ухаарч ойлгосон.		2	Бүтэн өгүүлбэрээр оновчтой тайлбарлан бичсэн бол 2 оноо
12	4.2в. Ж, Ч,Ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	Хэрэглэх	2 дээш үетэй үгийн дунд ж,ч,ш орсон үг олж бичээд залгаврыг зөв залгах		3	Зөв үг олсон үг тус бүр 0,5оноо, зөв залгасан залгавар тус бүр 0,5 оноо нийт 3 оноо

13	4.4а Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд, зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	Хэрэглэх	Холбох үгсийг зөв хэрэглэн өгүүлбэрээ утга төгс зохионо.		2	Холбох үгийг зөв хэрэглэн утга төгс өгүүлбэр зохиосон бол 2 оноо, дутмаг бол 1 оноо
14	4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх	Хэрэглэх	Өнгөрсөн хойно нь гэмших халаглах	Зөрүүд муйхар гэсэн утгатай үг	2	Бүтэн өгүүлбэрээр оновчтой тайлбарлан бичсэн бол 2 оноо
15	4.2ж Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих	Задлан шинжлэх	Уриалгыг бүтцийн дагуу эхлэл, гол, төгсгөл хэсгийг гаргаж утгын уялдаа холбоотой бичнэ.		5	Уриалгыг бүтцийн дагуу эхлэл, гол, төгсгөл хэсгийг гаргаж утгын уялдаа холбоотой бичнэ.

#### БИЧИХ ЧАДВАРЫН ҮНЭЛЭХ СИСТЕМ

№	ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР	Авах оноо	5 оноо
1	НАЙРУУЛАН БИЧИХ ЧАДВАР	- Эхлэл, гол, төгсгөл хэсгийг гаргасан бол 1 оноо	1 оноо
		- Үг, өгүүлбэрийг оновчтой сонгон, утгыг зөв гаргасан бол 2оноо	2 оноо
2	ЗӨВ БИЧИХ ЧАДВАР	- Зөв бичих дүрмийн алдаагүй бол 1 оноо	1 оноо
		- Үгийн тоонд багтааж бичсэн бол 1 оноо	1 оноо

## IV АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

Анги: .....

Сурагчийн нэр .....

ХУГАЦАА: 40МИН

НИЙТ 24 ОНОО

А ХУВИЛБАР

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

**САНАМЖ:** 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

#### Гэмшил

Дондог хүү гудамжнаас хөөрхөн халтар гөлөг тэврээд иржээ. Хүү хөлд орохоосоо л гөлгөнд дуртай хүүхэд байж. Ээж нь хүүгийнхээ сэтгэлийг бодоод “Хүү минь гараа л сайн угааж, хоол ундаа иддэг юм шүү” гэжээ. Дондог зав л гарвал гөлөгтэйгөө тоглож, орон дээрээ гарган эрхлүүлж, оровч гаравч дагуулна. Ингээд бүр аягатай хоол хувааж иддэг болов. Ээж нь сэтгэл зовж, гөлгийг эзэнд нь өгнө шүү гэв. Тэгснээ:

-Хүү минь нохойтой бүү тогло, өвчин халдварлана гэж учирлана.

-За ээж ээ, нохойтой тоглохгүйгээ, гараа угааж хоолоо иднэ гэж Дондог өгүүлнэ.

Ээжийгээ ажилд явмагц амласнаа мартаад гөлөгнийхөө ам, хамрыг гараараа илж тоглоно. Тэгтэл нэг өдөр толгой нь өвдөн, үе үе огиулан, хоол идэх дургүй болжээ. Ээж нь хүүгээ эмчид үзүүлжээ. Эмч цээжийг нь чагнаснаа:

-Хүү минь гараа харуул гэлээ. Гар нь хиртэй байв.

-Хүү минь нохойтой бүү тогло, хоол унд идэхийн өмнө гараа савандаж бүлээн усаар сайн угаа, тэгвэл ер өвдөхгүй. Хүүд бохир гарын өвчин хүрчээ. Одоо эмнэлэгт хэвтэж эмчлүүлнэ гэж эмч өгүүлэв.

Ээжийнхээ үгэнд орж гараа сайн угаасан бол ийм муухай өвчнөөр өвдөхгүй дээ гэж Дондог бодон ихэд гэмшин уйллаа. Тэгтэл эмч:

-Хүү минь тайвшир. Гэм нь урдаа гэмшил нь хойноо гэдэг юм. Нохойтой бүү тогло, гараа тогтмол угааж бай, мөдхөн эдгэнэ гэлээ. Дондог хүү хориод хоног эмнэлэгт хэвтэж эмчлүүлээд гарчээ.

Тэрбээр нохойд ойртохоо больж, хоол унд идэхийн өмнө гараа савантай бүлээн усаар тогтмол угаадаг болсон юм.

### СОНГОХ ДААЛГАВАР:

1.1 Хүү гудамжнаас юу олсон бэ?

А. бөмбөг

Б.гөлөг

В.тоглоом

Г. саван

1.2 Дондог хүү ээжийгээ ажилдаа явмагц, зав л гарвал яадаг байсан бэ?

А. Хоолоо хийж иддэг

В. Хичээлээ тогтмол хийдэг

Б.Гараа тогтмол угаадаг

Г.Гөлөгтэйгөө тоглодог

1.3 Дараах үгсийн алдаатай бичсэн үгийг олоорой.

А. сэтгэл

Б.тайвшир

В. өвчөн

Г.гэмшин

1.4 “Гэм нь урдаа гэмшил нь хойноо” зүйр цэцэн үгийн утгыг олж дугуйлаарай.

А. Буруу зүйлээ үл ухаарах

Б. Хэрэг учрыг гарахаас нь өмнө сэрэмжлэх

В. Гэм дутагдал нь бага багаар илрэх

Г. Аливаа зүйлийг бодож төлөвлөхгүйгээр хийх

1.5 Тохирох холбох үгийг сонгоно уу?

Хүү минь нохойтой бүү тогло, ..... өвчин халдварлана.

А.харин

Б.яагаад гэвэл

В.бөгөөд

Г. ийм учраас

1.6 Хүүгийн амьдралд ямар **өөрчлөлт** гарсан бэ?

- А. Гөлөг тэжээсэн.
- Б. Эмнэлэгт хэвтсэн.
- В. Хоол ундаа идэхийн өмнө гараа угаадаг болсон.
- Г. Бохир гарын өвчин туссан.

1.7 Эхийн үйл явдлыг дарааллын дагуу зөв дугаарласан хэсгийг олоорой.

1. Одоо эмнэлэгт хэвтэж эмчлүүлнэ.
2. Амлалтаа мартаж, гөлөгтэйгөө байнга тоглодог.
3. Ээж нь сэтгэл зовж, гөлгийг эзэнд нь өгнө шүү гэв.
4. Нохойд ойртохоо больж, хоол унд идэхийн өмнө гараа угаадаг болсон.

- А. 3,1,2,4
- Б. 2,3,1,4
- В. 1,3,2,4
- Г. 3,2,1,4

1.8 Үгийг утгаар нь зөв харгалзуулсан хэсгийн сонгоорой.

- 1. тараг                      А. цагаан идээ
- 2. тарга                      Б. малын хүч

- А. 1А, 2Б
- Б. 1Б, 2А
- В. 1А, 1Б
- Г. 2А, 2Б

1.9 “**Өөдлөх** айлын өнгө үүднээсээ” өгүүлбэрийн тодруулсан үгийг аль үгээр соливол өгүүлбэрийн утга өөрчлөгдөхгүй вэ?

- А. дээшлэх
- Б. уруудах
- В. дордох
- Г. эвтэй

1.10 “Амаа барих” хэлц үгийн утгад тохирохыг нь сонгоорой.

- А. Хүүхдүүд багшийн заасныг сайн ойлгох .
- Б. Ангид чанга дуугаар ярихгүй байх
- В. Гараараа амаа барих дасгал хийх
- Г. Буруу зүйл хийсэндээ гэмших

**ЗАДГАЙ ДААЛГАВАР:**

2.1 Чи энэ эхээс юуг ойлгож авсан бэ? Ойлгосноо 1 өгүүлбэрт багтаан бичээрэй. /2 оноо/

.....

.....

2.2 Дүрэмд тохирох жишээ үг тус бүр нэг, нэгийг олж бичээд -ийг, -ыг, -ийн, -ын, -ы, -ий залгаврын аль тохирохыг залгаж бичээрэй .

**Үгийн дунд орсон “ж,ч,ш”-ийн дараа “и” балархай эгшиг бичнэ.**

.....

.....

.....

2.3 Яагаад гэвэл гэсэн холбох үгийг хэрэглэн өгүүлбэр зохиож бичээрэй.

.....

2.4. “Толгой дээр гарах” хэлц үгийн утгыг илэрхийлсэн өгүүлбэр зохиож бичээрэй. /2 оноо/

.....

.....



## IV АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

Анги: .....

Сурагчийн нэр .....

ХУГАЦАА: 40МИН

НИЙТ 24 ОНОО

Б ХУВИЛБАР

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

**САНАМЖ:** 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

#### Гэмшил

Дондог хүү гудамжнаас хөөрхөн халтар гөлөг тэврээд иржээ. Хүү хөлд орохоосоо л гөлгөнд дуртай хүүхэд байж. Ээж нь хүүгийнхээ сэтгэлийг бодоод “Хүү минь гараа л сайн угааж, хоол ундаа иддэг юм шүү” гэжээ. Дондог зав л гарвал гөлөгтэйгөө тоглож, орон дээрээ гарган эрхлүүлж, оровч гаравч дагуулна. Ингээд бүр аягатай хоол хувааж иддэг болов. Ээж нь сэтгэл зовж, гөлгийг эзэнд нь өгнө шүү гэв. Тэгснээ:

-Хүү минь нохойтой бүү тогло, өвчин халдварлана гэж учирлана.

-За ээж ээ, нохойтой тоглохгүйгээ, гараа угааж хоолоо иднэ гэж Дондог өгүүлнэ.

Ээжийгээ ажилд явмагц амласнаа мартаад гөлөгнийхөө ам, хамрыг гараараа илж тоглоно. Тэгтэл нэг өдөр толгой нь өвдөн, үе үе огиулан, хоол идэх дургүй болжээ. Ээж нь хүүгээ эмчид үзүүлжээ. Эмч цээжийг нь чагнаснаа:

-Хүү минь гараа харуул гэлээ. Гар нь хиртэй байв.

-Хүү минь нохойтой бүү тогло, хоол унд идэхийн өмнө гараа савандаж бүлээн усаар сайн угаа, тэгвэл ер өвдөхгүй. Хүүд бохир гарын өвчин хүрчээ. Одоо эмнэлэгт хэвтэж эмчлүүлнэ гэж эмч өгүүлэв.

Ээжийнхээ үгэнд орж гараа сайн угаасан бол ийм муухай өвчнөөр өвдөхгүй дээ гэж Дондог бодон ихэд гэмшин уйллаа. Тэгтэл эмч:

-Хүү минь тайвшир. Гэм нь урдаа гэмшил нь хойноо гэдэг юм. Нохойтой бүү тогло, гараа тогтмол угааж бай, мөдхөн эдгэнэ гэлээ. Дондог хүү хориод хоног эмнэлэгт хэвтэж эмчлүүлээд гарчээ. Тэрбээр нохойд ойртохоо больж, хоол унд идэхийн өмнө гараа савантай бүлээн усаар тогтмол угаадаг болсон юм.

### СОНГОХ ДААЛГАВАР:

1.1 Хүү гудамжнаас юу олсон бэ?

А. тоглоом    Б. бөмбөг    В. гөлөг    Г. саван

1.2 Ээж нь хүүдээ юу гэж захидаг байсан бэ?

А. Нохойтой бүү тогло, өвчин халдварлана  
Б. Хичээлээ тогтмол хийж байгаарай  
В. Хоолоо сайн идэж байгаарай  
Г. Гөлөгийг эзэнд нь өгөөрэй

1.3 Дараах үгсийн алдаатай бичсэн үгийг олоорой.

А. сэтгэл    Б. өвчин    В. гэмшин    Г. тайвшар

1.4 “Гэм нь урдаа гэмшил нь хойноо” зүйр цэцэн үгийн утгыг олж дугуйлаарай .

А. Гэм дутагдал нь бага багаар илрэх  
Б. Буруу зүйлээ үл ухаарах  
В. Ямар нэг зүйл хийхээсээ өмнө бодох  
Г. Хэрэг учрыг гарахаас нь өмнө сэрэмжлэх

1.5 Тохирох холбох үгийг сонгоно уу?

Хүү минь нохойтой бүү тогло, .....өвчин халдварлана .

А. Харин    Б. Ийм учраас    В. Бөгөөд    Г. Яагаад гэвэл

1.6 Ээжийнхээ үгэнд ороогүйгээс хүүд юу тохиолдсон бэ?

- А. Хичээлдээ муудсан
- Б. Гөлөг нь алга болсон
- В. Бохир гарын өвчин хүрсэн
- Г. Гэр нь эмх замбараагүй болсон

1.7 Эхийн үйл явдлыг дарааллын дагуу зөв дугаарласан хэсгийг олоорой

- 1. Гараа савантай бүлээн усаар тогтмол угаадаг болсон.
- 2. Хүү аягатай хоолоо хувааж иддэг болов.
- 3. Хүү бохир гарын өвчин хүрчээ.
- 4. хүү минь нохойтой бүү тогло. Өвчин халдварлана .

А. 2,4,3,1

Б.2,3,1,4

В.3,2,4,1

Г.1,2,3,4

1.8 Зөв харгалзуулаарай.

- 1. арга                      А. савар
- 2. араг                     Б. ухаан

А.1А, 1Б

Б.2А, 2Б

В.1А, 2Б

Г.1Б, 2А

1.9 “Уруудах хүний унтах, идэх нь их” өгүүлбэрийн тодруулсан үгийг аль үгээр соливол өгүүлбэрийн утга өөрчлөгдөхгүй вэ?

А. өөдлөх

Б. өгсөх

В. доройтох

Г.дээшлэх

1.10 “Чихгүй толгойлох” хэлц үгийн утгад тохирохыг нь сонгоорой .

- А. Хүний ярих яриаг сонсохгүй байх
- Б. Бие биендээ худлаа ярих
- В. Чихгүй толгой зурах
- Г. Ахмад хүний үгэнд орохгүй байх

### ЗАДГАЙ ДААЛГАВАР:

2.1 Чи энэ эхээс юуг ойлгож авсан бэ? Ойлгосноо 1 өгүүлбэрт багтаан бичээрэй.

.....

.....

2.2 Дүрэмд тохирох жишээ үг тус бүр нэг, нэгийг олж бичээд -ийг, -ыг, -ийн, -ын, -ы, -ий залгаврын аль тохирохыг залгаж бичээрэй .

**Үгийн дунд орсон “ж,ч,ш”-ийн дараа “и” балархай эгшиг бичнэ.**

.....

.....

.....

2.3 **Ийм учраас** гэсэн холбох үгсийг хэрэглэн өгүүлбэр зохиож бичээрэй.

.....

2.4 “Буруу ишилсэн сүх шиг” хэлц үгийн утгыг илэрхийлсэн өгүүлбэр зохиож бичээрэй. /2 оноо/

.....

.....





